



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2014 ОНД САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНД

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**Улсын төсвийн хөрөнгө оруулалт, төсөл,
арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна.**

2015 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: Говьсүмбэр аймгийн аудитын газар Аймгийн тэргүүлэх аудитор Ш.Ичинхорлоо Аудитын менежер Д.Оюунбат Ахлах аудитор Ц.Батсайхан Аудитор Л.Отгонпүрэв 2015 оны 4 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3151 дугаарын утас, 7054 -3179 дугаарын факсаар харилцана уу ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 217 тоот	Товчилсон үгийн тайлбар4 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5 Бүлэг 1: Улсын төсвийн хөрөнгөөр орон нутагт эрх шилжсэн ажлаас 2 хөрөнгө оруулалтын ажлын эрхийг оройтож шийдвэрлэснээс ондоо багтаж хийгдээгүй санхүүжилт нь татагдсан, барьцаа хөрөнгө болон хяналтын зардлын тооцоог тухай бүр хийгээгүйгээс оны эцэст улсын төсөвт төвлөрүүлсэн, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт эрх шилжээгүй ажилд орон нутгаас хяналт тавих боломжгүй байгаа бөгөөд гүйцэтгэл нь удаашралтай, 2-3 жил дамжин хийгдэж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна. 1.1 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Үндэсний хөгжлийн цогц бодлого, МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан боловсруулсан байна. 1.2 Худалдан авах ажиллагааны аргыг оновчтой сонгож ажилласан байна. 1.3 Хөрөнгө оруулалтаар 5 төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн боловч 2 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй санхүүжилт нь татагдсан байна. 1.4 Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавьж буй захиалагчийн болон техник хяналтын үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжсэн байна. 1.5 Хөрөнгө оруулалтын зарим ажлын техник хяналтын зардал болон тендерийн барьцаа хөрөнгийг буруу тооцоноос улсын төсвийн дансанд төвлөрүүлсэн байна. 1.6 Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг бодитой дүгнэж, хөрөнгүүдийг данс бүртгэлд бүрэн тусгаж, гүйцэтгэгчид хариуцлага тооцож ажилласан байна. Бүлэг 2: Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Худалдан авах ажиллагааны алба, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрууд нь хоорондоо ажлын уялдаа холбоогүй ажилласнаас аймгийн ИТХТ-ийн тогтоолыг зөрчиж, батлагдсан төсөвт өртгөөс илүү дүнгээр гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан, Мөн тендер шалгаруулалтын ажлыг хугацаанд нь зохион байгуулаагүйгээс хөрөнгө оруулалтын ажил оройтож, он дамжин хийгдэж байгаа нь төлөвлөсөн ажил хугацаандаа хэрэгжихгүй байгаагаас гадна, ажлын чанар үр дүнд сөргөөр нөлөөлж байна. 2.1 Хөрөнгө оруулалтыг орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэн оновчтой төлөвлөж, хэрэгжүүлсэн байна. 2.2 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу үр дүнтэй зохион байгуулан ажилласан байна. 2.3 Орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлууд үр дүнтэй хэрэгжиж байгаа боловч зарим ажил улирлын байдлаас шалтгаалан он дамжин хэрэгжиж байна. 2.4 Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавьж буй захиалагчийн болон техник хяналтын үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. 2.5 Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг бодитой дүгнэж, данс бүртгэлд тусгаж, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцож ажилласан байна. Дүгнэлт Зөвлөмж Холбогдох байгууллагын санал: Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал Саналд өгсөн тайлбар Хавсралтууд
--	--

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт: 2014 оны Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитын хамарсан хүрээ: Аудитаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг төсвийн ерөнхийлөн захирагч, холбогдох байгууллага болон аймаг орон нутагт эрх нь шилжсэн хөрөнгө оруулалтын ажлыг хамруулан шалгана.

Аудитын арга зүй: Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, албан тушаалтнуудтай ярилцлага хийх, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авч, харьцуулан шинжлэх, түүвэрчлэн шалгах зэрэг аудитын арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитыг үндэсний аудитын газар болон аймгийн Аудитын газрын 2015 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, ГАГ-ын нэгдсэн удирдамж, аймгийн Аудитын газрын дэд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Төрийн аудитын хуулиар тодохойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “2014 онд Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн”-д хийх гүйцэтгэлийн аудитыг 2015 оны 1 дүгээр сарын 2-ноос 4 дүгээр сарын 15 хүртлэх хугацаанд ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор Л.Отгонпүрэв нар хийж гүйцэтгэлээ.

Бүлэг 1

Улсын төсвийн хөрөнгөөр орон нутагт эрх шилжсэн ажлаас 2 хөрөнгө оруулалтын ажлын эрхийг оройтож шийдвэрлэснээс ондоо багтаж хийгдээгүй санхүүжилт нь татагдсан, барьцаа хөрөнгө болон хяналтын зардлын тооцоог тухай бүр хийгээгүйгээс оны эцэст улсын төсөвт төвлөрүүлж, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт эрх шилжээгүй ажилд орон нутгаас хяналт тавих боломжгүй байгаа бөгөөд гүйцэтгэл нь удаашралтай, 2-3 жил дамжин хийгдэж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

1.1.Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Үндэсний хөгжлийн цогц бодлого, МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан боловсруулсан байна.

Тус аймагт 2014 онд Улсын төсвөөс буюу Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцаас аймгийн төвийн 12 жилийн 1 дүгээр дунд сургуулийн их засварын ажилд 400.0 сая, Шивээговь сумын 12 жилийн 3 дугаар дунд сургуулийн дээврийн их засварын ажил 15.0 сая төгрөг, Эрчим хүчний сайдын багцаас Хонхор хотгоны 6 кв-ын кабель шугамын өргөтгөл шинэчлэлтийн ажил 105.0 сая төгрөг, Барилга, хот байгуулалтын сайдын багцаас Баянтал сумын гадна бохир ус, дулааны шугамын ажил 117.4 сая төгрөг, Баянтал сумын гадна дулаан, цэвэр усны шугамын ажил 315.4 сая төгрөг, Эрүүл мэндийн сайдын багцаас Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасгийн агааржуулалтын системийг шинээр хийх ажил 90.0 сая төгрөг, Соёл, спорт аялал жуулчлалын сайдын багцаас аймгийн Спорт хорооны барилгын их засварын ажил 121.0 сая төгрөг, нийт 1,163.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдсан байна.

Дээрх хөрөнгө оруулалтын ажлууд нь Үндэсний хөгжлийн цогц бодлого, МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймаг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдсан байна.

1.2.Худалдан авах ажиллагааны аргыг оновчтой сонгож ажилласан байна.

2014 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 16 хөрөнгө оруулалтын ажил хэрэгжихээс Аврах гал унтраах ангийн барилга, Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн барилга, Нийгмийн даатгалын хэлтсийн оффисын барилга, Канад цэцэрлэгийн барилгын ажил зэрэг нийт 5 хөрөнгө оруулалтын ажлын тендер шалгаруулалт хариуцсан яамдадаа явагдаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан бөгөөд дээрх ажлууд он дамжин хийгдэж байна.

Эдгээрээс аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн оффисын барилга 2015 оны 1 дүгээр сард ашиглалтанд орсон ба бусад хөрөнгө оруулалтын ажлын эрх нь орон нутагт шилжиж ирээгүй ба барилга угсралтын ажлууд дутуу гүйцэтгэлтэй байна.

Бусад 10 хөрөнгө оруулалтын ажлуудын эрх нь орон нутагт шилжин ирж аймгийн тендерийн үнэлгээний хорооноос тендер шалгаруулалтыг зохион байгуулж, Баянтал сумын гадна дулаан, цэвэр усны шугамын ажил, Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасгийн агааржуулалтын систем шинээр хийгдэх ажлууд нь нээлттэй тендер шалгаруулалтаар гүйцэтгэгч байгууллагыг сонгосон бол, Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн дотор их засвар, Баянтал сумын гадна бохир усны шугамын ажил,

ССАЖГ-ын гадна дулаан, бохирын шугамын засварын ажлууд нь нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулсан боловч тендерт оролцогч байгууллагуудын холбогдох бичиг баримт материалууд шаардлага хангаагүйгээс шалгаруулалт хийгдээгүй ба гүйцэтгэгч байгууллагатай шууд гэрээ байгуулан ажиллуулсан байна. Дээрх хөрөнгө оруулалтын ажлууд гэрээний хугацаандаа ашиглалтанд орсон байна.

Мөн Хөдөө аж ахуйн яамнаас инженерын хийцтэй 8 худаг гаргах ажлын тендер шалгаруулалт орон нутагт зохион байгуулагдсан боловч эрх нь шилжиж ирээгүй байна. Үүнээс Сүмбэр суманд 1, Баянтал суманд 1, Шивээговь суманд 3, нийт 5 худгийг гаргаж ашиглалтанд хүлээлгэн өгсөн ба 3 худгийн усны ундрага нь техникийн нөхцлийн шаардлагыг хангаагүй учраас мэргэжлийн байгууллага дүгнэлт гаргасан тул ажлыг нь зогсоож санхүүжилтийг олгоогүй байна.

1.3. Хөрөнгө оруулалтаар 5 төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн боловч 2 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй санхүүжилт нь татагдсан байна.

Орон нутагт эрх нь шилжсэн 7 хөрөнгө оруулалтын ажлаас 5 хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжиж, 2 хөрөнгө оруулалтын ажил хэрэгжээгүй байна. Үүнд: Шивээговь сумын 12 жилийн 3 дугаар дунд сургуулийн дээврийн ажлын эрх нь орон нутагт оройтож шилжиж ирснээс тендер зарлаж, гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулах хугацаагүйгээс, Хонхор хотхоны 6 кв-ын кабель шугамын өргөтгөл, шинэчлэлийн ажлын нээлттэй тендер шалгаруулалт явуулж “Эрчим өргөө” ХХК-тай 2014.06.17-ны өдөр гэрээ байгуулсан боловч гэрээний үүргээ биелүүлж ажиллаагүйгээс гэрээг цуцалсан, дахин тендер шалгаруулах хугацаа байхгүй болсон учир тус тендерүүдийн санхүүжилт нь буцааж татагдсан байна.

1.4.Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавьж буй захиалагчийн болон техник хяналтын үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжсэн байна.

Гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан 10 гэрээнд тусгай нөхцөл, хариуцлага тооцох асуудлуудыг бүрэн тусган ажилласан байна. Аймгийн ХБХ болон ГХБХБГ-ын мэргэжилтнүүд захиалагчийн хяналтыг сайн тавьж ажилласан байна. Тухайлбал: Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасгийн агааржуулалтын систем шинээр хийх ажил дээр магадлашгүй ажлын зардал гараагүй тул 1.6 сая төгрөгийн санхүүжилтийг хасаж тооцсон, бүх төсөл, арга хэмжээнээс Барилгын тухай хуулийн дагуу 2.5-5 хувийн барьцаа хөрөнгө авч үлдсэн, их засварын ажлуудыг цаг хугацаанд нь чанартай сайн гүйцэтгүүлсэн байна.

1.5.Хөрөнгө оруулалтын зарим ажлын техник хяналтын зардал болон тендерийн барьцаа хөрөнгийг буруу тооцсоноос улсын төсвийн дансанд төвлөрүүлсэн байна.

Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн дотор их засварын ажлаас хяналтын зардалын зардалд 7.0 сая төгрөг, тендерийн барьцаа хөрөнгөнд 10.0 сая төгрөг нийт 17.0 сая төгрөгийг тухайн байгууллагаас суутган тооцож, холбогдох байгууллагуудын дансруу шилжүүлэлгүйгээр улсын төсөвт төвлөрүүлсэн зөрчил илэрлээ. Иймд тус 17.0 сая төгрөгөөр холбогдох санхүүгийн тайланд өглөг, авлагаар бүртгэн тайлагнаж,

тендерийн барьцааны 10.0 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлж, хяналтын зардлын 7.0 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт бичив.

1.6.Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг бодитой дүгнэж, хөрөнгүүдийг данс бүртгэлд бүрэн тусгаж, гүйцэтгэгчид хариуцлага тооцож ажилласан байна.

Эрх нь шилжсэн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгүүдийг эзэмшиж, ашиглаж байгаа байгууллагуудын данс бүртгэлдээ бүрэн тусгасан байна.

Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасгийн агааржуулалтын систем шинээр хийж ажлыг хийсэн “Агаар салхивч” ХХК нь гэрээний хугацаагаа 3 хоногоор хэтрүүлсэн бөгөөд 0.025 сая төгрөгөөр алданги тооцсон байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн үү?

Бүлэг 2

Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Худалдан авах ажиллагааны алба, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрууд нь хоорондоо ажлын уялдаа холбоогүй ажилласнаас аймгийн ИТХТ-ийн тогтоолыг зөрчиж, батлагдсан төсөвт өртгөөс илүү дүнгээр гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан,

Мөн тендер шалгаруулалтын ажлыг хугацаанд нь зохион байгуулаагүйгээс хөрөнгө оруулалтын ажил оройтож, он дамжин хийгдэж байгаа нь төлөвлөсөн ажил хугацаандаа хэрэгжихгүй байгаагаас гадна, ажлын чанар үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

2.1.Хөрөнгө оруулалтыг орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэн оновчтой төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар автозамын сангаас аймгийн төвийн авто замыг засварлах 64.9 сая төгрөг, Байгаль хамгаалах сангаас Соёл, амралтын хүрээлэн байгуулахад 170.2 сая төгрөг, Монгол улсын Засгийн газрын “Ногоон хэрэм хөтөлбөрийн хүрээнд ойн зурвас байгуулах ажилд 22.0 сая төгрөгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор баталж хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь ард иргэдийн ая тухтай орчинд амрах хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.

2.2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу үр дүнтэй зохион байгуулан ажилласан байна.

Орон нутагт хөрөнгө оруулалтын 7 ажил хэрэгжсэнээр аймгийн төвийн авто засварын ажил Монгол улсын Засгийн газрын “Ногоон хэрэм хөтөлбөрийн хүрээнд ойн зурвас байгуулах ажил, Соёл, спорт, амралтын хүрээлэнгийн ногоон байгууламжийн усалгааны ус нөөцлөх сав суурилуулах, ус түгээх шугамын ажлын зардал зэрэг 3 ажил харьцуулалтын аргаар хийгдсэн бөгөөд Соёл, спорт, амралтын хүрээлэнгийн хашааг томсгож, шинээр барих зардал болон Соёл, спорт, амралтын хүрээлэнд мод тарих, услах, арчлах ажлыг нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулсан боловч тендерт оролцох байгууллагын тоо хүрээгүйгээс гүйцэтгэгч байгууллагатай шууд гэрээ байгуулсан байна.

2.3.Орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлууд үр дүнтэй хэрэгжсэн боловч тендер шалгаруулалтын ажлыг хугацаанд нь зохион байгуулаагүйгээс хөрөнгө оруулалтын ажил оройтож, он дамжин хийгдэж байгаа нь

төлөвлөсөн ажил хугацаандаа хэрэгжихгүй байгаагаас гадна, ажлын чанар дүнд сөргөөр нөлөөлж байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн бөгөөд Соёл, спорт, амралтын хүрээлэнд мод тарих, услах, арчлах ажлын гэрээг сунгаж он дамжуулан хийхээр болсон байна. Энэ нь тендер шалгаруулалтыг тариалалт хийх хугацаанаас хойш зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсантай холбоотой байна.

2.4.Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавьж буй захиалагчийн болон техник хяналтын үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн болон техникийн хяналтын үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжсэн байна. Тухайлбал: Сүмбэр сумын Хонхор хотхоны 8-р байр, НДХ-ийн зам талбайн засварлах ажлыг “Грэйтроуд” ХХК нь, авто машины зогсоол болон замын зузааныг 20 см хийх ёстой байтал техникийн тодорхойлолтын дагуу хийлгээгүйгээс 3 см дутуу буюу 17 см-ийн зузаантай хийсэн байсныг хяналтын үеэр илрүүлэн үүрэг даалгавар өгсөн боловч Улсын комисс хүлээж авах үед уг даалгаварыг биелүүлээгүй тул санхүүжилтээс нь 7.0 сая төгрөгийг хасаж, буцаан төвлөрүүлсэн байна.

Мөн Соёл, амралтын хүрээлэнд ногоон байгууламжийн усалгааны худаг гаргах ажлыг “Ус-Ундрах” ХХК нь гүйцэтгэсэн ба худгийн гүнийг 120 метрээс багагүй байхаар гэрээний техникийн нөхцөлд заасныг зөрчиж худгийн гүнийг 110 метр гаргаж техникийн тодорхойлолтын дагуу хийгээгүй тул 1 тууш/м өрөмдлөгийн зардлыг 0.015 сая төгрөгөөр тооцож 10 м дутуу ажлыг 1.5 сая төгрөгийг хасаж, гэрээг дүгнэн үлдэгдэл санхүүжилтийг олгосон байна.

2.5. Санхүү төрийн сангийн хэлтэс болон Худалдан авах ажиллагааны алба, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрууд нь хоорондоо ажлын уялдаа холбоогүй ажилласнаас аймгийн ИТХТ-ийн тогоолыг зөрчиж, батлагдсан төсөвт өртгөөс илүү дүнгээр гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан байна.

Аймгийн ИТХТ-ийн тогтоолоор 64.9 сая төгрөгийг баталсан байхад Худалдан авах ажиллагааны алба нь төлөвлөгөө батлахдаа 69.9 сая төгрөгөөр батлан, тендер шалгаруулалтаар сонгогдсон гүйцэтгэгч байгууллагатай 5.0 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгохоор гэрээ байгуулсан байна.

2.5.Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг бодитой дүгнэж, данс бүртгэлд тусгаж, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцож ажилласан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн хөрөнгүүдийг АИТХТ-ийн тогтоолын дагуу холбогдох байгууллагууд нь данс бүртгэлдээ бүрэн тусгаж, тайлагнасан байна. Мөн гэрээний техникийн тодорхойлолтын дагуу хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авахдаа дутуу хийгдсэн ажлуудын хэмжээгээр санхүүжилтийг хасаж тооцсон байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

Д Ү Г Н Э Л Т

Нэг дэх зорилтын хүрээнд:

Улсын төсвийн хөрөнгөөр орон нутагт эрх шилжсэн ажлаас 2 хөрөнгө оруулалтын ажлын эрхийг оройтож шийдвэрлэснээс ондоо багтаж хийгдээгүй санхүүжилт нь татагдсан, барьцаа хөрөнгө болон хяналтын зардлын тооцоог тухай бүр хийгээгүйгээс оны эцэст улсын төсөвт төвлөрүүлсэн;

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт эрх шилжээгүй ажилд орон нутгаас хяналт тавих боломжгүй байгаа бөгөөд гүйцэтгэл нь удаашралтай, 2-3 жил дамжин хийгдэж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

Хоёр дахь зорилтын хүрээнд:

Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Худалдан авах ажиллагааны алба, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрууд нь хоорондоо ажлын уялдаа холбоогүй ажилласнаас аймгийн ИТХТ-ийн тогтоолыг зөрчиж, батлагдсан төсөвт өртгөөс илүү дүнгээр гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан,

Мөн тендер шалгаруулалтын ажлыг хугацаанд нь зохион байгуулаагүйгээс хөрөнгө оруулалтын ажил оройтож, он дамжин хийгдэж байгаа нь төлөвлөсөн ажил хугацаандаа хэрэгжихгүй байгаагаас гадна, ажлын чанар үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

ХБХ-ийн дарга Н.Оргилмаад

- Барилгын тухай хуулийн дагуу гүйцэтгэгч байгууллагын тендерийн барьцаа хөрөнгийг барьцааны дансанд байршуулж, бүрэн төвлөрүүлж байх
- Улсын төсвөөс хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд хийсэн захиалагчийн хяналтын зардлыг ГХБХБГ-т бүрэн олгож байх

ГХБХБГ-ын дарга Мөнхгэрэлд

- Захиалагчийн хяналтын зардлаа хяналт хийсэн тухай бүр ажлын гүйцэтгэлээ гаргаж тооцоо нийлж баталгаажуулж байх.

ХАА-ны албаны дарга Ц.Ундралд

- Аймгийн ИТХТ-ын тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалтын төсөвт өртөгт багтаан тендер зарлаж, гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулж байх.

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Н.Одонтуяад

- Захиалагчийн хяналтын зардал 7.0 сая төгрөг, хөрөнгийн барьцааны орлого 10.0 сая төгрөг, нийт 17.0 сая төгрөгийг Орон нутгийн нэгдсэн тайланд өглөг авлагаар тусгах.
- Аудитаар тавигдсан төлбөрийн актыг хугацаанд нь барагдуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

211900 Чойр, Говьсүмбэр аймаг
Утас/факс: (01-542) 31-18, E-mail: GSAimag@yahoo.com

2015. 04. 09 № 09/467
тантай 2015. 04. 09-ны № 40 -т

АУДИТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх тухай

2014 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцаад, дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн барилгын дотор их засварын ажлын хяналтын болон барьцаа хөрөнгийн зардал болох 17,0 сая төгрөгийг холбогдох данснууд руу шилжүүлэлгүйгээр улсын төсөвт төвлөрүүлсэн тул барьцааны 10,0 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлж, хяналтын зардлын 7,0 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт бичсэн байна.

Захиалагчийн хяналтын гэрээний дагуу тухайн ажлын гүйцэтгэлийн хяналтыг хэрхэн хэрэгжүүлснээс шалтгаалж, хяналтын ажлын тайлан, тухайн төслийн чанар байдлыг харгалзан хяналтын зардлыг бүрэн олгох эсэхийг шийддэг билээ. Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн их засварын ажлын хувьд 2014 оны жилийн эцсийн байдлаар Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас тухайн ажил дээр захиалагчийн хяналтыг хэрхэн хэрэгжүүлж ажилласан тухай ажлын тайлан ирүүлээгүй байсан тул 7,0 сая төгрөгийг 100% Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт олгоно хэмээн балансын өглөг, авлагад тусгах боломжгүй байсан болно.

Бид улсын төсөвт төвлөрүүлсэн дээрх хөрөнгийг буцаан төвлөрүүлж, зохих данснуудад нь байршуулах арга хэмжээ авч эхлээд байгаа тул дээрх төлбөрийн акт бичиж буй асуудлыг эргэн харж, дахин нягталж өгнө үү.

ДАРГА



Б.БАТДЭЛГЭР

03 0048

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Аймгийн Засаг даргын тамгын газрын тайлангийн төсөлд өгсөн 2015.04.27-ний өдрийн 01/467 тоот албан бичигтэй танилцаад тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэж байна.